

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга* 0

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-6

---

*1. Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай  
хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр,  
нийгмийн хамгааллын сайдын мэдээлэл сонсох* 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны  
11 дүгээр сарын 27-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 49 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, М.Ганхүлэг, М.Сарнай;  
Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ж.Баярмаа, С.Зулпхар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Б.Түвшин;  
Тасалсан: Х.Булгантуяа, Ж.Чинбүрэн.

**Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээлэл сонсох**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсролын болон Эрүүл мэндийн сайдын мэдээллийг хамтад нь сонсох шаардлагатай тул хуралдааныг хойшлуулах горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, С.Эрдэнэбат, Д.Үүрийнтуяа, Х.Болормаа нар үг хэлэв.

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Боловсролын болон Эрүүл мэндийн сайдын мэдээллийг хамтад хэлэлцэхээр тогтож, уг асуудлыг хойшлуулав. /16:03/

*Хуралдаан 14 минут үргэлжилж, 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 03 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим,  
15 цаг 49 минут

### НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Энхнасан:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Ариунзаяа гишүүн, Ганмаа гишүүн, Нарантуяа-Нара гишүүн, Эрдэнэбат гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Идэрбат гишүүн, Саранчулуун гишүүн, Үүрийнтуяа гишүүн, Болормаа гишүүн, Мөнхтуяа гишүүн оролцож байна.

Мөн өнөөдөр Бейсен гишүүн, Ганхүлэг гишүүн, Сарнай гишүүн бол гадаадад томилолттой байгаа юм байна. Зулпхар гишүүн чөлөө хүссэн. Гадаад хэргийн яаманд өөр ажил давхардсан. Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэж ирж, Байнгын хорооны ирц 52,4 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

**Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг сонсоно.**

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Мөнхтуяа гишүүн. Мөнхтуяа гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хүүхэд хамгааллын тухай хууль 2024 оны 1 сарын 17-нд батлагдаж, 2024 оны 9 сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн хууль байгаа. Энэ хуулийн 23 дугаар зүйлд боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал, 24 дүгээр зүйлд эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын асуудлыг ингээд тусгасан байна. Жишээ нь 23.5.1-д “боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг Боловсролын сайд батална” гэж байгаа юм. 24.5.1 дээр “эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг Эрүүл мэндийн сайд батална” гэж заасан байгаа юм.

Тэгэхээр хүүхэд хамгааллын асуудал бол дан ганц Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Энх-Амгалан сайдын хариуцах асуудал бас биш. Энэ бол салбар дундын уялдаа холбоо шаардагдах нарийн төвөгтэй процесс юм.

Жишээ нь, саяхан зөвшөөрөлгүй хүүхэд харах үйлчилгээнд 1 ой 2 сартай хүүхэд эндээд, энэ дээр манай Боловсролын сайд бас надад хамаагүй Гэр бүл, хөдөлмөрийн яаманд хамааралтай гээд ингээд өөрөө уснаас хуурай гарсан ийм муухай жишээнүүд бол байгаа. Тийм учраас хүүхэд хариуцсан бусад сайдуудыг оруулж ирж энэ асуудлаа ярилцъя гэж бодож байна. Эрүүл мэндийн сайд баймаар байна. Боловсролын сайд баймаар байна. Энэ асуудал дээр. Гадаад хэргийн сайд

ч энд бас хамаатай шүү дээ. Гадаадад байгаа хүүхдийн асуудал яригдана шүү дээ. Гадаадад ажиллаж, амьдарч байгаа хүүхдүүдийн асуудал. Тэгэхээр би ийм саналтай байна.

**Л.Энхнасан:** Эрүүл мэндийн яамнаас бол Хуулийн хэлтсийн дарга, Боловсролын яамны бас төлөөлөл байгаа. Тэгэхээр Эрүүл мэндийн яамны бас төлөөллүүд байгаа. Өнөөдөр төлөвлөсөн ёсоороо хэлэлцүүлэх нь зүйтэй л байх. Мөнхтуяа гишүүний саналыг дэмжихээр санал хураалт хийе.

Дэмжинэ. Хойшлуулъя гэсэн томъёоллоор бусад сайд нараа байлцуулж байгаад Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдыг байлцуулж байгаад. Тэгэхдээ холбогдох яамны албан тушаалтнууд байгаа. Саяын томъёоллоор сайд нарыг байлцуулаад хойшлуулъя гэсэн саналыг дэмжихээр санал хураалт хийе. Мөнхтуяа гишүүний санал 54,5 хувиар дэмжигдсэн учраас хурлыг хойшлуулъя. Идэрбат гишүүн үг хэлье гэж байна. Микрофоныг өгчих.

**Ц.Идэрбат:** Өнөөдөр ингээд Хүүхэд хамгааллын хууль 9 сарын 1-ээс эхэлж хэрэгжиж эхэлсэн. Тэгээд энэ Хүүхэд хамгааллын хууль дээр саяын Мөнхтуяа гишүүний гаргасан энэ зарчмын саналууд бол яг л туссан байгаа л даа. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа бол ганцхан тухайн яамных биш, салбар дундын үйл ажиллагаа юм гээд. Тэгэхээр нэгэнт бид нар Байнгын хорооны хурлыг яг ийм учир шалтгаанаар хойшлуулж байгаа бол тийм шийд гарчихлаа шүү дээ. Тэгэхээр дараагийн хуралдаан дээр энэ Загсийн газрын гишүүд яг өөрийн энэ салбар дундын уялдаа холбоог хүүхэд хамгаалал дээр яаж хангаж байгаа юм бэ гэдэг дээр нэлээн тийм дэлгэрэнгүй мэдээлэлтэй ирээсэй. Тэгэхгүй юу гэдэг юм энэ чинь төсөв батлах ёстой. Салбарын бодлого байх ёстой. Тэгээд яг энэ зүйлүүд тусгагдсан юм уу, үгүй юм уу.

Нөгөө талдаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол яг энэ хууль дээр туссан амин чухал 1 заалт бол урьд нь Монгол Улс хүүхэд хамгааллын хуультай байсан. Гэхдээ Олон улсын байгууллага, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сангаас бол танай хууль хэтэрхий ерөнхий байна. Хэн юу хийх нь мэдэгдэхгүй, ямар төгрөг, хөрөнгө хаанаасаа гаргах нь ойлгомжгүй ийм байгаа учраас энэ хүүхэд хамгааллын хуулиа өөрчлөөч гэдэг ийм зөвлөмжүүд ирсэн учраас 2024 оны нэг сард энэ хууль батлагдсан. Тэгээд энэ дээр Гэр бүлийн хуулийг дагуулаад, нэгд одоо яг энэ ирээд байгаа зөвлөмжтэй холбоотой нэг чухал заалт орсон нь аймаг, сум, нийслэлийн төсвийг төслийг тухайн шатын Иргэдийн хуралд өргөн барихдаа хүүхэд хамгааллын болон гэр бүлийн хүчирхийллийн зардлыг төсвийн төсөлдөө тусгаж өргөн барина гэсэн нэг том зүйл заалт орсон. Энэ бол энэ хууль хэрэгжихийн гол бас амин сүнс нь болов уу гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр энэ холбогдох яам нь өнөөдөр энэ Монгол Улсын 330 сумын иргэдийн хурал, тухайн шатын Засаг дарга нар 21 аймаг, 9 дүүргийн Засаг дарга нар төсвийн төслөө өргөн барьчихсан байгаа. Яг энэ явц ямархуу түвшинд явж байгаа юм бэ. Өргөн барьсан юм уу, бариагүй юм уу. Барихдаа тэр хүүхэд хамгааллын зардлыг тусгасан юм уу, үгүй юм уу гэдэг дээр бас нэлээн тийм тодорхой мэдээлэлтэй ирвэл энэ хуулийн бид нар хэрэгжилтийг ярих энэ Байнгын хорооны хурал нэлээн тийм өндөр ач холбогдолтой болно гэж ингэж бас үзэж байгаа юм. Тэрнээс хэн хэндээ нэг анхан шатын мэдлэг олгох ийм харилцан асуулт одоо бол хэрэггүй шүү дээ. Нэгэнт хууль дээр заачихсан үүргээ хэрхэн

биелүүлж байна вэ гэдэг дээр л бид ярилцах ёстой. Өнгөрсөн 1 сард батлагдсанаас хойш хэрэгжих хүртэл 8 сарын хугацаа орхисон. Тэгээд энэ хугацаанд бол бас энэ хуулийг ялангуяа төрийн албан хаагч нар тухайн шийдвэр гаргагч нар бол бас судалж, дараа дараагийн үйл ажиллагаандаа төлөвлөх хангалттай хугацаа байгаа, байсан гэж ингэж үзэж байгаа учраас яамны сайд, холбогдох албан тушаалтнууд зүгээр статистик мэдээлэл өгнө гэхээсээ илүүтэйгээр яг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар 10-15 минутын танилцуулга бэлдэж ирвэл илүү үр дүнтэй болно. Тэгээд Байнгын хорооны зүгээс энэ тал дээр нь бас анхаарч өгөөрэй л гэж бас хүсэх гэж байгаа юм. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Зөв зөв. Өнөөдрийн энэ хэлэлцүүлэг бас төсөв хэлэлцэхтэй холбоотой яг энэ хүүхэдтэй холбоотой төсвүүд яг хаана, ямар газар 2025 онд тусгагдаж байна. Төсөв хэлэлцэхтэй холбоотойгоор хасагдах гэж байгаа тийм төсөл байна уу гэсэн илүү тэр чиглэлээр ярья гэж байсан. Тийм болохлоор бас Идэрбат гишүүний хэлж байгаа саналын дагуу ажлын алба бас энд анхаарч ажиллаарай. Дараа зөвхөн сайд нарыг оролцуулаад ч биш хамтарсан 2 Байнгын хороо бас хэлэлцүүлбэл бүр үр дүнтэй болж магадгүй юм байна. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгнө үү.

**С.Эрдэнэбат:** Яах вэ өнөөдөр бол нөгөө төсөв хэлэлцэж байгаа учраас яаралтай хоолой дээр тулчихсан юмаа яриад авъя гэдэг үүднээс нь ойлгосон. Гэхдээ яг Мөнхтуяа гишүүний хэлдэг юм нь бол зарчмын хувьд бол зөв. Бид нар ингээд яг хурал эхлэнгүүт нэг ийм поверпойнт бид нарт өгөөд, тэгээд бид нар энэ дээр нь тоог нь харж байгаад энэ чинь яачихсан юм, тэр чинь яачихсан юм гэдэг ийм байдлаар цаашаа явмааргүй байна. Тэгэхээр тодорхой хугацаа заагаад, гэхдээ их удаагаад яах вэ. Тийм учраас энэ дээр Засаг дарга нар хүртэл энэ чинь үүрэгтэй байгаа. Мөн хүүхдийн хамгааллын байгууллагаас гадна нөгөө эрүүл мэнд, боловсрол гээд тухайн асуудал хариуцсан бүр мэргэжлийн боловсрол дээр хүртэл байгаа байхгүй юу. 15, 16 настай хүүхдүүддээ хөдөлмөр эрхлүүлнэ гээд МСҮТ-н тийм шинэ хуулиуд хүртэл явж байгаа. Тэр утгаараа мэдээллүүдийг нь өгөөд, тэгээд чиглэл өгөхдөө юу гэж өгмөөр юм бэ дээ. Ийм зузаан зузаан поверпойнт дэлгэрэнгүй байхыг бид нар бол уншина. Урьдчилж уншаад, яг бид нараар ер нь Байнгын хороогоор юу шийдүүлэх гээд байгаа юм. Хууль хоорондынх нь асуудал яг юу байгаа юм гэдэг дээрээ тавихгүй бол бид нар чинь үндсэндээ асууж, хариулсаар байтал хайран цаг маань дуусчихдаг. Тэгээд Их Хурал руу энэ чухал чухал асуудлууд бас хоцорчих гээд байдаг учраас энэ тал дээр бол бас анхаарч өгнө үү гэдгийг бас хэлэн маар байна.

Тэгээд дээрээс нь яах вэ, энэ дээр энэ хүүхэд хамгааллын чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудын хийж байгаа сайн туршлага юу байна вэ. Ажилчдынхаа хүүхдүүдийг ингээд яадаг маш олон аж ахуйн нэгж, байгууллагууд байдаг. Тэр талаар нь энэ ажил олгогчдын байгууллага ч гэдэг юм уу, аж ахуйн нэгж, байгууллагын эрх зүйн хүрээндээ шийдэж байгаа тийм туршлага энэ тэр байх юм бол бас бид нарт өгвөл магадгүй энэ хууль тогтоомж дээр нэмэлт, өөрчлөлт оруулах ч гэдэг юм уу, заавал хуулиар зохицуулаагүй үлдчихсэн байгаа асуудлуудыг хүртэл хэлэлцэх гэдэг ийм зүйлүүдийг хүртэл хэлэлцэхэд бол хэрэг болох болов уу гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгнө үү.

**Д.Үүрийнтуяа:** Гишүүдтэй адил саналтай нэмээд хэлэхэд нэгэнт бид нар энэ асуудлыг хэлэлцэх хугацааг хойшлуулж байгаа юм чинь хэлэлцэх асуудал маань ч гэсэн тийм байгаа шүү дээ. Энэ хуулийн хэрэгжилтийг авч үзнэ гээд байгаа шүү дээ. Ярилцана гээд байгаа юм. Тэгэхээр 9 сарын 1-ээс хойш үндсэндээ 3 сарын хугацаа өнгөрлөө. Энэ 3 сарын хугацаанд хуулийн хэрэгжилт ямар байдлаар явж байгаа юм. Энэ дээр ямар тулгамдсан асуудлууд гарч байгаа юм. Магадгүй энэ хуулийн талаар энэ чинь 2024 оны 1 сарын 1-нд, оны эхэнд боловсруулсан хууль 9 сарын 1-ээс хэлэлцэхээр 9 сарын хугацаанд бид нарт хуулийг сурталчлах, таниулах боломж байлаа. Энэ хугацаанд хуулийг сурталчлах, таниулах чиглэлээр ямар зүйлүүд хийгдсэн юм. Ялангуяа энэ нийгэм сошиалд Хүүхэд хамгааллын тухай хуультай холбоотой янз янзын буруу зөрүү ойлголтууд, ташаа мэдээллүүд нэлээдгүй явж байна шүү дээ. Тэгэхээр яг энэ хуулийг сурталчлан таниулах чиглэлээр ямар ажлууд хийв гэдэг юмыг үзмээр байгаа юм. Одоо ингээд бэлтгэгдээд ороод ирж байгаа слайдыг аваад л үзэхээр баахан статистик мэдээллүүд байгаад байна. Гэтэл хууль дээр бид нар 2025 оны 1 сарын 1-ээс эхлээд Гэр бүл, хүүхэд хамгааллын ажилтантай сум болгонд байна гээд заачихсан. Гэтэл энэ маань яг төсөвтөө тэр хуульд заасан заалтуудыг хэрэгжүүлэх зардлууд нь орсон уу, үгүй юу гэдгээс эхлээд яг энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг тусгайлан авч үзмээр байна. 3 сарын хугацаанд гэсэн үг.

**Л.Энхнасан:** Болормаа гишүүн үг хэлье. Микрофоныг нь өгнө үү.

**Х.Болормаа:** Баярлалаа. Тэгээд гишүүддээ бас баярлалаа. Яагаад гэхээр би бас анхан шатан дээрээ олон жил бас ажилласан хүний хувьд дүүргийн Засаг даргаар бас 8 жил ажилласан. Тэгэхээр яг энэ хүүхэд хамгаалах, хүүхдийн эрхийн тухай энэ хуулиуд ерөөсөө хэрэгжилт бол үнэхээр маш хүндрэлтэй, дутмаг байдаг. Тэгээд сая би бас Байнгын хорооны хурал дээр хэлэлцэх асуудлыг бас гайхаж л байсан л даа. Яагаад гэхээр шинэчилсэн найруулга маань сая 2024 оны 1 сарын 1-нд гээд, хэрэгжих хугацаа маань сая 9 сарын 1-ээс гэж байгаа юм. Тэгэхээр энэ өнгөрсөн хугацаанд бид нар бол сонгуулиас сонгуулийн хооронд байсаар байгаад л өнгөрсөн шүү дээ. Тэгэхээр энэ гүйцэтгэл гэдэг маань юу байгаад ингэж орж ирж байна гэсэн нэг ийм бас гайхширалтай байсан учраас бусад гишүүдтэйгээ санал нэг байна.

Үнэхээр бодит амьдрал дээр нэгжүүд дээр хамаарал бүхий энэ яам, Тамгын газрууд маань өнөөдөр яг бодит амьдрал дээр, тэгээд бусад нэгжүүд дээр яаж хэрэгжиж байна гэдэг маань үнэхээр бүрхэг байгаа. Тэгэхээр би бас тодорхой хэмжээнд ажилласан хугацааныхаа бас кэйсүүдийг дараагийн бас хурал дээр бас ярилцъя гэж бодож байна. Тэгээд бүх гишүүддээ баярлалаа гэж хэлье.

**Л.Энхнасан:** Ойлголоо. Хүүхдийн эрхийн тухай хууль. Энэ чинь бол өмнө нь хэрэгжиж байгаа хууль шүү дээ. Нөгөөдөх нь Хүүхэд хамгааллын тухай хууль бол 9 сарын 1-ээс шинээр хэрэгжиж байгаа энэ 2 хууль учраас. Хурлыг хойшлуулсныг мэдэгдье.

16.03 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*